InvesCore
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

# “ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2021 оны 04-р сарын 23-ны өдөр №A/01 Улаанбаатар хот

*Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай*

“Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 8.5.10 дахь заалт, болон Тооллогын комиссын 21/02 дугаар шийдвэрийг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА**

**Д. БАЯСГАЛАН**

“ИНВЕСКОР ББСБ” ХК
InvesCore FINANCIAL INSTITUTION
6060854 1119286063
УЛААНБААТАР ХОТ

InvesCore
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

# "ИНВЕСКОР ББСБ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2021 оны 04-р сарын 23-ны өдөр № А/02 Улаанбаатар хот

*Хоёрдогч өглөгт хөрвүүлэх тухай*

"Инвескор ББСБ" ХК ("**Компани**" гэх)-ийн ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.11 дэх заалт, Компанийн дүрмийн 8.5.11 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, заавар батлах тухай" 71 тоот тогтоолын 5.2.2 дэх заалт, болон Тооллогын комиссын 21/02 дугаар шийдвэрийг үндэслэн тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмын дагуу өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Компанийн 85%-ийг эзэмшдэг "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-аас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар авсан зээл болон хуримтлагдсан хүү болох нийт 10,677,000,000 (арван тэрбум зургаан зуун далан долоон сая) төгрөгийг хоёрдогч өглөгт хөрвүүлэхийг зөвшөөрсүгэй;
2. Хоёрдогч өглөгрүү шилжүүлэхтэй холбогдуулан "Хоёрдогч өглөг"-ийн гэрээг хянаж, батлахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Б. Анхболд/-д даалгасугай;
3. Энэхүү тогтоолын хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хороонд хоёрдогч өглөгийг бүртгүүлэхэд холбогдох материалыг бүрдүүлж өгөх, болон бусад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д даалгасугай;
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох шаардлагатай арга хэмжээг авч ажиллан, ажлын үр дүнг танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/-д даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА**

**Д. БАЯСГАЛАН**

InvesCore
FINANCIAL INSTITUTION
6060854 1119286063
УЛААНБААТАР ХОТ

InvesCore
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

# “ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2021 оны 04-р сарын 23-ны өдөр № А/03 Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны төсөв батлах тухай*

“Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах заалт, Компанийн дүрмийн 8.5.14 дэх заалт, болон Тооллогын комиссын 21/02 дугаар шийдвэрийг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагаанд шаардагдах төсвийг Хавсралтаар баталсугай.

“ИНВЕСКОР ББСБ” ХК

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА**

**Д. БАЯСГАЛАН**